

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН УУРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ ХЭРДЭНЭБИЛЭГ

2019 оны ... сарын ... өдөр

УХА0183 2826046

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

2020 оны 05-р сарын 08 өдөр

Улаанбаатар хот

1. Зорилго:

НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбарууд, Баянхшуу дэд төвийн цэвэрлэгээ, үйлчилгээ болон дэлхий нийтийг хамарсан цар тахал коронавирус /covid-19/-ын халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл ахуй, халдвартайжүүлэлтийг хангах, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэхэд оршино.

2. Хамрах хүрээ:

НЗЗ-ны байрууд, НҮНТ-ын салбарууд, Баянхшуу дэд төв

3. Хугацаа:

2020 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийг дуустал.

4. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

| | |
|---|---------------|
| Орлогч дарга | Б.Галмандах |
| Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан | Т.Итгэл |
| Их эмч | Н.Энхзаяа |
| Хүний нөөцийн ажилтан | Н.Булганчимэг |

5. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиглэл:

5.1 Хяналтын хуудсын асуултуудын хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

5.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа, түүний мөрдөлтөд хяналт тавих;

5.3 Шаардлагатай гэж үзсэн бусад ажил;

6. Бусад:

6.1 Ажлын хэсэг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ холбогдох баримт бичгийг судлах, асуулга явуулах зэрэг дүн шинжилгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

6.2 Хяналтын хуудас нь энэхүү удирдамжийн салшгүй хэсэг байна.

6.3 Ажлын хэсгийн гишүүд хариуцсан чиглэл тус бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аливаа дутагдал, түүний шалтгаан нөхцөл, арилгах арга замын тухай саналыг боловсруулж, газрын даргад танилцуулна.

НЭЭЗ-НЫ БАЙРУУД, НҮНТ-ИЙН САЛБАРУУД, БАЯНХОШУУ ДЭД ТӨВИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ УЙЛЧИЛГЭЭ, ЭРҮҮЛ АХҮЙ,
ХАЛДВАРГҮЙЖУУЛЭЛТ ЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ХЯНАЛТЫН ХУУДАС

2020.05.08.

| Д/д | Асуултууд | Хяналтын огноо | Авсан оноо | |
|-------------|---|-------------------|----------------|---------|
| | | | Лягжинхэрэлбээ | Минимум |
| 1 | Байруудын цэвэрлэгээний чанар | 0 | 4 | |
| 2 | Халдвартгүйтгэл, ариутгалыг заавар, зөвлөмжийн хүрээнд хийж, бүртгэл, тэмдэлэл хөтөлсөн эсэх | 0 | 5 | |
| 3 | Шинэ коронавирус /Covid-19/-ын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж байгаа эсэх /халуун хэмжих, маск зуухийг шаардах, гар ариутгал, хүний гар байнга хүрдэг хэсгийн ариутгал, зохион байгуулсан бусад ажил/ | 0 | 4 | |
| 4 | Хорхой, шавж, амьттан байгаа эсэх | 0 | 6 | |
| 5 | Багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг хангасан байдал | 0 | 7 | |
| 6 | Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийн бүрэн бүтэн байдал | 0 | 7 | |
| 7 | Цэвэрлэгээний материалын эмх цэгч, цэвэр байдал | 0 | 7 | |
| 8 | Цэвэрлэгээ УЙЛЧИЛГЭЭНД гарсан гомдол санал | 0 | 7 | |
| Нийт | | 0 | 47 | |

ХЯНАЛТЫН ХУУДАС БӨГЛӨСӨН:

**НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТЭС**
ИЛТГЭХ ХУУДАС

Н33-ны байрууд, НҮНТ-ийн салбаруудын цэвэрлэгээ,
үйлчилгээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай

2020 оны 05 дугаар сарын 21

Улаанбаатар хот

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын даргын баталсан удирдамжийн дагуу Н33-ны байрууд, НҮНТ-ийн салбаруудын цэвэрлэгээ, үйлчилгээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэгт орлогч дарга Б.Галмандах, их эмч Н.Энхзаяа, хүний нөөцийн менежер Н.Булганчимэг, дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан Т.Итгэл нар ажилласан ба 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс 05 дугаар сарын 18-ны өдрүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлгээ.

Ажлын хэсэг газрын даргын 2018 оны А/44 дүгээр тушаалаар батлагдсан "Бодлогын болон захирамжлалын баримт бичгийн хэрэгжилт, Нийтлэг үйлчилгээний газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх журам", хяналтын хуудасны нийт 8 шалгуур үзүүлэлтийн хүрээнд оноогоор дүгнэлээ.

1. Цэвэрлэгээ, үйлчилгээний талаар:

Гүйцэтгэлийн хувийг нэгтгэж хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1

| д/д | Асуултууд | Авсан оноо | | | | | | | | | | Дундаж гүйцэтгэл |
|-----|---|------------|--------|--------|--------|-------------------|----------------------|-------------|-------|--------|----------------------|------------------|
| | | 1 байр | 2 байр | 3 байр | 4 байр | 5 байр "А" корпус | 5 байр "Б, В" корпус | Дунжингарав | Мишэл | Драгон | Баянхошуу Дэд төв | |
| 1 | Байруудын цэвэрлэгээний чанар | 93.7 | 87.5 | 93.7 | 93.7 | 93.7 | 93.7 | 100 | 93.7 | 93.7 | | 93.7 |
| 2 | Халдвартгүйтгэл, ариутгалыг заавар, зөвлөмжийн хүрээнд хийж, бүртгэл, тэмдэглэл хөтөлсөн эсэх | 35 | 35 | 55 | 20 | 30 | 30 | 100 | 85 | 50 | | 48.9 |
| 3 | Шинэ коронавирус /Covid-19/-ын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж байгаа эсэх | 100 | 87.5 | 12.5 | 81.2 | 87.5 | 18.7 | 81.2 | 87.5 | 81.2 | Унэлгээх боломжгүй | 70.8 |

| | | | | | | | | | | | |
|------|--|------|------|------|------|------|------|------|------|------|------|
| | /халуун хэмжих, маск зүүхийг шаардах, гар ариутгал, хүний гар байнга хүрдэг хэсгийн ариутгал, зохион байгуулсан бусад ажил/ | | | | | | | | | | |
| 4 | Хорхой, шавж, амьттан байгаа эсэх | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 87.5 | 91.6 | 83.3 | 95.8 |
| 5 | Багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг хангасан байдал | 100 | 96.4 | 100 | 92.8 | 100 | 92.8 | 100 | 100 | 100 | 98.0 |
| 6 | Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийн бүрэн бүтэн байдал | 92.8 | 96.4 | 96.4 | 89.2 | 89.2 | 100 | 89.2 | 82.1 | 85.7 | 91.2 |
| 7 | Цэвэрлэгээний материалын эмх цэгц, цэвэр байдал | 92.9 | 82.1 | 78.5 | 67.8 | 100 | 71.4 | 92.8 | 89.2 | 96.4 | 85.7 |
| 8 | Цэвэрлэгээ үйлчилгээнд гарсан гомдол санал | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 |
| Нийт | | 89 | 86 | 80 | 81 | 88 | 76 | 94 | 91 | 86 | 85.5 |




График 1. Гүйцэтгэлийн хувь

Графикаас харахад НҮНТ-ийн Дүнжингаав салбар 94%, Мишээл салбар 91% буюу “Бүрэн хангалттай”, НЗЗ-ны 1-р байр 89%, 2-р байр 86%, 3-р байр 80%, 4-р байр 81%, 5-р байрны А корпус 88%, Драгон салбар 86% буюу “Хангалттай”, 5-р байрны Б, В корпус 76% буюу “Ажил сайжруулах шаардлагатай” тус тус үнэлэгдсэн байна.

Шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл /хувь/




График 2. Гүйцэтгэлийн хувь

Шалгуур үзүүлэлтээр дүгнэхэд халдвартгүйтгэл, ариутгалыг заавар, зөвлөмжийн хүрээнд хийж, бүртгэл тэмдэглэл хөтөлсөн байдал, шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээ үнэлгээ бага гарсан байна. Байр хариуцсан менежерүүд энэ төрлийн арга хэмжээг заавар зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлж байгаа гэх боловч бүртгэл, тэмдэглэл хөтлөөгүй байсан нь үнэлгээг бууруулах шалтгаан болсон байна. Мөн дээрхи графикаас харахад цэвэрлэгээний материалын эмх цэгцийг сайжруулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Дүгнэлт:

Үйличлгээний албаны цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал халдвартгүйжүүлэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 85.5% буюу “Хангалттай” үнэлгээтэй дүгнэгдлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх явцад ажилтан, албан хаагчдаас гаргасан ноцтой зөрчил, дутагдал байхгүй бөгөөд Баянхшуу дэд төвийн менежер ажлын байранд байгаагүй шалтгаанаар тус төвийг үйл ажиллагааг дүгнээгүй бөгөөд цаашид ажлын цаг ашиглалтыг сайжруулах үүргийг байр хариуцсан менежерт өглөө.

Байруудад ариутгал, халдвартгүйтгэл хуваарийн дагуу хийгдэж, цэвэрлэгээ үйлчилгээнд гарсан саналгүй, хөдөлмөр хамгааллын зөрчил дутагдалгүй ажиллаж байгаа боловч зарим зөрчил дутагдлыг тухай бүр нь байр хариуцсан менежер, ажилтнуудад танилцуулж, зөрчлийг арилгах үүрэг даалгавар өгсөн.

Цаашид авах арга хэмжээ:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын хэсгээс үйлчилгээний албаны дарга М.Алтантуяд дараах зөвлөмжийн дагуу зохих арга хэмжээг авч ажиллан биелэлтийг газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор тайлагнах үүрэг өгөв. Үүнд:

- “Бүрэн хангалттай” үнэлгээ авсан:

HYNT-ийн Мишээл, Дүнжингарав салбарууд

- Дүгнэгдсэн үнэлгээг бууруулахгүй ажиллах;

- “Хангалттай” үнэлгээ авсан:

H33-ны 1, 2, 3, 4, 5-р байрны А корпус, HYNT-ийн Драгон салбар

- Ариутгал халдвартгүйжүүлэлт хийсэн тухай тэмдэглэл хөтлөх;
- Шинэ корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг хүрээнд хийгдэж буй арга хэмжээний чанарыг сайжруулах /H33-ны 3-р байр/;

- “Ажил сайжруулах шаардлагатай” үнэлгээ авсан:

H33-ны 5 дугаар байрны Б, В корпус

- Ариутгал халдвартгүйжүүлэлт хийсэн тухай тэмдэглэл хөтлөх;
- Шинэ корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг хүрээнд хийгдэж буй арга хэмжээний чанарыг сайжруулах;
- Цэвэрлэгээний багаж, хэрэгсэл, материалын эмх цэгцийг сайжруулах;

ТАНИЛЦСАН:

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЭРДЭНЭБИЛЭГ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
ОРЛОГЧ ДАРГА



Б.ГАЛМАНДАХ

ИХ ЭМЧ



Н.ЭНХЗАЯА

ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТАН




Н.БУЛГАНЧИМЭГ

ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН



Т.ИТГЭЛ

ИЛТГЭХ ХУУДАС ХҮЛЭЭН АВСАН:
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА



М.АЛТАНТУЯА